



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 326

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

“Авто тээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газарт хийсэн баримтын шалгалтаар тус үйлдвэрийн газар нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т үйлдвэрийн газрын захирал нь “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэж заасныг зөрчин санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй, төлөвлөгөөгүй 37.5 сая төгрөгийн зардал санхүүжүүлсэн, үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй 215.0 сая төгрөгийн үргүй зардал гаргасан, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар өөрийн чиг, үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг санхүүгийн жил эхлэхээс 3 сарын өмнө гаргаж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Сангийн ямаар зардлын дээд хязгаарыг батлуулна” гэж заасныг зөрчин 67.8 сая төгрөгийн зөвшөөрөлгүй хөрөнгө бэлтгэсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйл, 12 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмыг зөрчин 477.9 сая төгрөгийн худалдан авалтыг зохион байгуулсан зэрэг нийт 798.2 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Авто тээврийн үндэсний төв” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Авто тээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Гүрсоронзонд дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, гүйцэтгэх захиралтай байгуулсан Контрактаар олгосон эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулах, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй зардал, хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхгүй байх;

2.2. Зорчигч тээврийн ажил үйлчилгээг алдагдалгүй явуулах, орлого, зардлын зохистой харьцааг барьж ажиллах талаар эдийн засгийн үндэслэлтэй тооцоо судалгаа хийж, дүгнэлт гаргах, “Авто тээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газраас тээвэрлэгч аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээний нөхцөлийг сайжруулж, зорчигч тээврийн үйлчилгээнээс олдог 4, 8, 10 хувийн орлогыг

300589

нэмэгдүүлэх, гэрээг шинэчлэн баталж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт танилцуулах;

2.3. Зорчигч тээврийн ажил, үйлчилгээг зохион байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн хүрээнд нээлттэй сонгон шалгаруулалт хийж тээвэрлэгч компаниудад ил тод, нээлттэй, өрсөлдөх тэгш боломжийг олгож ажиллах, тендерийн баримт бичгийн оролцогчийн тусгай шаардлагад үнэ өртөг, үндэслэлийг тодорхой тусгах, гэрээгээр баталгаажуулах;

2.4. Үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд цахим банк нэвтрүүлэх үйл ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийг дагаж мөрдөх;

2.5. “Гэрэгэ Системс” ХХК-иар 2019 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хойших хугацааны талбайн түрээс, интернет, засвар үйлчилгээний зардлыг гэрээний дагуу төлүүлж, орлогыг Улсын төвлөрсөн төсөвт нөхөн төвлөрүүлэх;

2.6. “Гэрэгэ Системс” ХХК-ийн Киоск машинаар бичигдсэн билетийн орлогыг эрсдэлээс хамгаалахад шаардлагатай барьцаа төлбөр байршуулах зохицуулалтыг гэрээнд тусгаж хэрэгжүүлэх, билетийн орлого Авто тээврийн үндэсний төвийн дансанд шууд шилжих техникийн боломжийг судлан үзэж шийдвэрлэх;

2.7. Худалдан авах ажиллагаанд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөн ажиллах;

2.8. Цаашид шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх чиглэлээр удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.9. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА


З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТЭСИЙН
ДАРГА

Ц. ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн
32.6 тогтоолын хавсралт



“Авто тээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газарт хийсэн
шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах
арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах нэгж	Мөнгөн дүн /сая төгрөгөөр/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Нэмэгдэл цалин урамшуулал	Захиргаа, сургалт хүний нөөцийн хэлтэс, Санхүү, эдийн засгийн хэлтэс	37.5	Эрх бүхий байгууллагаас баталсан бүтэц орон тоо, цалингийн санд багтаан цалинг тооцож олгох.
2	Үргүй зардал	Санхүү, эдийн засгийн хэлтэс	215.0	Үйлдвэрийн газрын үйл ажиллагаатай холбоотой зардлаас бусад зардлыг санхүүжүүлэхгүй байх.
3	Тендерийн баримт бичигт заасан шаардлага хангаагүй тендер шалгаруулсан, орон нутгийн шатахуун	Захиргаа, сургалт хүний нөөцийн хэлтэс, Санхүү, эдийн засгийн хэлтэс	477.9	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн дагуу тендерийг үнэлэх, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөн ажиллах.
4	Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй үндсэн худалдан авсан	Захиргаа, сургалт хүний нөөцийн хэлтэс, Санхүү, эдийн засгийн хэлтэс	50.1	Үндсэн хөрөнгийг батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу худалдан авах.
5	Батлагдсан зардал хэтрүүлсэн	Захиргаа, сургалт хүний нөөцийн хэлтэс, Санхүү, эдийн засгийн хэлтэс	17.7	Батлагдсан төлөвлөгөө, хууль журмыг мөрдөн ажиллах.
	Нийт дүн		798.2	